



Залуусын дунд зарлаж буй хүний эрхийн 2 дахь чэллэнж

2019 оны 3-р сарын 22-нд “Хэнийг ч орхихгүй” уриан дор тэмдэглэх **Дэлхийн усны өдрийг** тохион НҮБ-ын Ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Лео Хеллер, Испани, Герман улсын Төлөлөгчийн газрууд, UN-Water, UNESCO-IHP, and OHCHR байгууллагуудтай хамтран ундны ус, ариун цэврийн байгууламжтай байх хүнийг эрхийн тухай залуучуудын мэдлэг, ойлголтыг сайжруулахын тулд **Хүний эрхийн 2 дахь цахим чэллэнжийг** зарлаж байна.

Хүний эрхийн 2 дахь цахим чэллэнжийн сэдэв:

Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжтай байх хүний эрх гэр орноос бусад орчинд хэрхэн хэрэгжиж байна вэ?

Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжтай байх нь хүний эрх юм.

Энэхүү эрх нь гэр орноос бусад орчинд буюу нийтийн орон зай болох цэцэрлэгт хүрээлэн, төмөр зам, ажлын байр, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн байр, мұхлаг, дэлгүүр, цэргийн хуаран, хорих анги зэрэгт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Учир нь 2030 он гэхэд хүн болгонд ундны ус, ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй байлгах зорилгод хүрэхийн тулд эдгээр нь нийтийн газар болгонд эдгээр байгууламжууд байх ёстой юм.

Уралдаанд хэн оролцож болох вэ?

15-24 насны залуучууд ба 2019 оны 3-р сарын 22-ны байдлаар 24 настай байх ёстой.

Уралдааныг хэрхэн шалгаруулах вэ?

Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжтай байх нь хүний эрх гэдгийг ойлгож өөрийн

бүтээл туурвилдаа гаргасан, болоод энэ асуудал нь залуучуудад хэрхэн хамаарч байгаа тухай ойлгомжтох хэллэг дүрслэлээр гаргасан онлайн контентыг шалгаруулна.

Иймээс асуудлыг сайтар ойлгосон, мөн бүтээлч шинэлэг байдлаар асуудлыг хөндсөн контент ялна.

Чэллэнжид хэрхэн оролцох вэ?

- Тусгай илтгэгч өөрийн хуудастай Instagram (@UNSRwatsan), Facebook (SRwatsan) ба Twitter (@SRwatsan) сошиал платформууд дээр #Youth4watsan хэштагтай өөрийн гаргасан контентоо хуваалцна.
- Тусгай илтгэгчийн хуудсыг таглана.
- Өөрийн контентын линзийг илгээж болно.
- Контентыг өөр ямарч сошиал платформ дээр байршуулж болно.
- Хэдэн ч контент гаргаж байршуулан илгээж болно.

Хугацаа:

- Контентыг сошиалоор байршуулах хугацаа 2019 оны 2-р сарын 28-ны Женевын 17 цагаар төгсгөвөр болно.

Ялагчийг зарлах:

- Уралдааны ялагчийг **Дэлхийн усны өдөр буюу** 2019 оны 3-р сарын 22-нд зарлана.

Шагнал:

Ялагчийг 2019 оны 9-р сард Швейцарын Женев хотноо урин залж НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 42-р хурлын үеэр Тусгай илтгэгчийн зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцуулж үг хэлэх эрхээр шагнана!

Швейцарь явах аялалын зардлыг даана.

Женевт 2019 оны 9-р сарын 6-7-нд очсон байна. Хугацааг жич тодруулна.

Нэмэлт мэдээлэл:

Ялагчаар насанд хүрээгүй хүн тодорвол хууль ёсны харгалзах хүний хамтаар аялна. Виза, аялалын даатгалыг аялагч өөрөө даана.

Асуулт /тодруулга:

Нэмэлт асуулт, тодруулгыг srwatsan@ohchr.org хаяг руу илгээнэ үү?

Нэмэлт мэдээллийг:

<https://www.ohchr.org/EN/Issues/WaterAndSanitation/SRWater/Pages/PreviousPublications.aspx>